



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН
НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

2026 онд мөрдөх бүтэц орон тоог
шинэчлэн батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/535 дугаар тушаал “Насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагааны журам”-ын 3.1, 3.2 дахь хэсэг, Боловсролын сайд, Сангийн сайдын 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/135, А/68 дугаар хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт “Аймаг дүүргийн Насан туршийн суралцахуйн төвийн орон тооны хязгаарын жишиг нормтаивыг мөрдөх заавар”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус төвд 2026-2027 оны хичээлийн жилд захиргаа аж ахуйн ажлыг 9, сургалтын үйл ажиллагааг 17, нийт 26 үндсэн орон тооны бүрэлдэхүүнтэйгээр байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулж, хавсралтаар баталсугай.

2.Физик, математик, хөгжим, биеийн тамир, түүх нийгэм, газарзүй, хими биологийн багшийг цагаар авч ажиллуулахыг менежер (П.Мөнхтуяа)-д үүрэг болгосугай.


3. Үндсэн орон тооны багш, ажилчдыг хавсралтад заагдсан ажлын чиг үүргийн дагуу сургалт, судалгааны ажлыг зохион байгуулж ажиллахыг сургалтын алба (П.Мөнхтуяа, Б.Бярсайхан) нарт үүрэг болгосугай.



Б.ГЭРЭЛГУА

1626010001

Баянгол дүүргийн Насан туршийн суралцахуйн төвийн захирлын 2026 оны 01 сарын 02 өдрийн А/01 дугаар тушаалын хавсралт



НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН ШИНЭЧИЛСЭН
ОРОН ТООНЫ БҮТЭЦ

2026 оны 01 дүгээр сарын 02

Улаанбаатар хот

Д/д	Орон тооны нэршил	Орон тоо	
Захиргаа, аж ахуйн орон тоо			
1	Захирал	1	
2	Нягтлан бодогч	1	
3	Архив, бичиг хэргийн ажилтан	1	
4	Зохион байгуулагч	1	
5	Эмч	1	
6	Нярав	1	
7	Сэтгэл зүйч	1	
8	Цахилгаанчин /сантехникч/	1	
9	Манаач	4	
10	Үйлчлэгч	1	
Бүгд		13	
Сургалтын албаны орон тоо			
	Орон тооны нэршил	Ажлын чиг үүрэг	
11	Байгууллагын төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан менежер	Насан туршийн суралцахуйн бодлогын хэрэгжилтийг тухайн орон нутгийн онцлогт нийцүүлэн төвийн үйл ажиллагаанд төлөвлөн зохион байгуулах, холбогдох мэдээ, тайланг цаг хугацаанд нь үр дүнд суурилсан байдлаар тайлагнах, арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, хамтын	1

		ажиллагааг бэхжүүлэ өргөжүүлэхэд чиглэх	
12	Иргэдийн боловсрол нөхөн олгох, эзэмшүүлэх, бичиг үсгийн боловсрол, сургалт үйлчилгээ хариуцсан менежер	Албан боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадаагүй хүүхэд, насанд хүрэгчдэд суурь, бүрэн дунд боловсрол олгох, нөхөн эзэмшүүлэх сургалт, үйл ажиллагааг боловсрол, сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулж, тайлагнах	1
13	Хувь хүний хөгжил хариуцсан менежер	Иргэдийн насан туршдаа сурлцахуйд дэмжлэг үзүүлж, хувь хүний ур чадварыг нэмэгдүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулах, орон нутгийн холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, тайлагнах	3
14	Цахим ур чадвар мэдээлэл технологи хариуцсан менежер	Насан туршийн суралцахуйн мэдээллийн технологийн асуудлыг хариуцан, төвийн үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, иргэдийн цахим мэдлэг, технологийн ур чадварыг нэмэгдүүлэх сургалт нөлөөллийн ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, тайлан, судалгаа, хийж ажиллана.	1
15	Амьдрах ухааны ур чадвар хариуцсан менежер	Иргэдийн ажил амьдралын орчноос үүсэж буй хэрэгцээнд нийцүүлэн амьдрах ухааны мэдлэг чадвар олгох сургалтыг орон нутгийн холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах, иргэдийн эрэлт	1

		хэрэгцээний судалгаа явуулах мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх	
16	Албан бус боловсролын багш	Орон нутгийн ялгаатай хэрэгцээтэй иргэдийг боловсролд хамруулах, монгол хэл, бичиг гадаад хэлний мэдлэгийг нэмэгдүүлэх, цахим ур чадварт суурилсан цаг хугацаа, орон зайг үл хамааран суралцахад дэмжлэг үзүүлж, сургалтын агуулгыг дүйцүүлэн боловсрол сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулах	6
	Үндсэн ажилтан		26
	Нийт		26